



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2025.09.15 № 37

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА С.БЯМБАЦОГТ ТАНАА

Эрчим хүчний үнэ тариф, салбарын  
бодлогын хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна.

Эрчим хүчний салбарт төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилтийн талаар дараах мэдээллийг ирүүлнэ үү. Үүнд:

1.Хэрэглэгчдэд борлуулах цахилгаан болон дулааны тарифыг шинэчлэн тогтооход инфляцийн өсөлтийг тооцож үзсэн эсэх, холбогдох судалгаа мэдээлэл, үнэ нэмэх болсон шийдвэрүүд;


2.Хэрэглэгчдэд борлуулах цахилгаан болон дулааны тарифын өсөлтийн хувь хэмжээ болон ямар шатлалаар нэмэгдүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээллүүд болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Л.МӨНХБАЯСГАЛАН



2025000001